

## V. Эрийн гурван наадмын түүхээс

### МОНГОЛЫН ЭРТНИЙ БӨХИЙН ЗАН ЗАНШИЛ, ӨМСГӨЛ ХУВЦАСНЫ ТУХАЙД

Б.Цогзолмаа.  
СУИС-ийн докторант.

*Өгүүллийн товч утга: Монголчуудын эртний бөхийн барилдааны нэг хэлбэр "Бух ноолдоон"-ы ёс жаяг, зан заншлын тухай өгүүлэх болно.*

*Түлхүүр үг: Бөх, бух ноолдоон, өмсгөл хувцас, бөгс, шалбуур, шуудаг, хөтөлбөр, уяа мөрий, хөтөлгөө, сумо...*

Эрт дээр үеэс бөхийн дээдэлдэг монгол хүн болохоороо бөх судлалын ажилд сэтгэлээ зориулан явдаг нэгэн би билээ. Би монгол бөхийн үүсэл хөгжил, зан заншил барилдааны арга мэх, бөхчүүдийн зан төрх, бие бялдрын хөгжил, өмсгөл хувцасны хувьсал өөрчлөлт гээд л судлах, сонирхох зүйлийнхээ баримтыг цуглуулж, аман судалгааны ажлаар хөдөө орон нутгаар явж, эрдэмтэд, судлаачид, бөхчүүд, бөх сонирхогчид, хөгшчүүлтэй санал бодлоо солилцож явахууд төрсөн сэтгэгдэлдээ хөтлөгдөн баруун монголын "бух ноолдоо"-ныг сонирхон Ховд хотод болсон олон улсын эрдэм шинжилгээний VI бага хуралд тодорхой санаа, оноо дэвшүүлсэн илтгэл тавьж, санал солилцохын зэрэгцээ багагүй баримт, мэдээлэл цуглуулж ирсэн юм. Цуглуулсан мэдээ, хэрэглэгдэхүүндээ тулгуурлан монголчуудын эртний бөх болох "Бух ноолдоон"-ы өмсгөл хувцас, ёс жаяг, зан заншлын тухай бөх судлаач сонирхогчидтой бодол, санаагаа хуваалцмаар байна.

Саяхан болтол орон нутгийн шинжтэйгээр уламжлагдан хүч үзэн тэмцэлдэж байсан сонирхолтой барилдааны нэг бол ойрад монголчуудын бух ноолдоон (ноцолдоон, авалдаан) мөн.

Баяд, дөрвөд, торгуудын бух ноолдооны тухай А.Очир, Г.Батнасан, Д.Баасан, Д.Баяр, Б.Буяннэмэх нарын судлаачид өгүүлэл бичиж байжээ. Энэ барилдаан нь XIX зууны эцэс хүртэл баруун монголын торгууд, захчин өөлд, монгол урианхайд, баяд, дөрвөд ястны дунд "бух авалдаан", "бух барилдаан", "бух ноолдоон" гэх зэрэг нэрээр уламжлагдаж иржээ. Увсын баяд, дөрвөд нар 1930-аад он хүртэл бух ноолдооноор барилдаж, эрийн гурван наадмаа хийдэг байсныг нутгийн настан буурлууд хуучилдаг.

Бух ноолдоонд оролцогчид зөвхөн "бөгс" хэмээх өмсгөл өмсдөг. Бөгсийг (одоогийн шуудагтай төстэй) буга, марал, бух, аргал тэхийн арьсаар хийнэ. Арьс, ширийг урь идүүлсэний дараа шүүдэж, талхих зэргээр элдэн, хонгор шаргал өнгөтэй болгож боловсруулаад, өмсгөлийг хийдэг байжээ. Бух ноолдооны бөхчүүд цээж нүцгэн барилдана. Бөгсөн биеэр өмсөх өмсгөлийг шалбуур, шуудаг, бөгс гэж янз янзаар нэрлэдэг байжээ. Шалбуурын хэлбэр хэрэглээ нь одоогийн үндэсний бөхийн шуудагтай төстэй. Шалбуурын дээд зах, хоёр шуумгийг (одоогийн богино өмд гэсэн үг) гадагш нь хуруу илүү (гурван см орчим) нугалан оёод, түүгээр эр сур гүйлгэн, уяа бэлтгэнэ. Шалбуурыг өмсөөд захыг эгц өмнө нь, шуумгийг хоёр ташаан дээр нь чангалан уядаг. Бүдүүн шөрмөсөн утсаар шалбуурыг ороолгосон (ташуулдан) чиглэлээр нэвтгэлзэн ширж, бөхөлсөн байна. Шалбуурын хоёр ташаанд нь хар булигаар, шир зэргээр эвэр угалз хайчлан хадаж бөхлөн гоёодог байжээ. Хар буюу улаан өнгийн зүйлээр шалбуурын ар голд нь хан гарьд, бүргэд мэт хүчит жигүүртний дүрсийг урлан шаглаж үйлдсэн байна.

Бөх судлаач Л.Ням-Осор 1985 онд Увс аймгаас "Бух барилдаан"-ы бөхийн шуудаг олжээ. Энэ нь бөх Түгж, түүний эцэг бөх Очир нар үе улируулан эдэлж хэрэглэж яваад, одоо Очирын хүү аймгийн арслан Намбагт шилжин үлдээд

байгаа хувцас боловч бидэнд үл мэдэгдэх хэдэн үеийг урьд нь дамжсан болох нь тодорхой юм. Бөхчүүд буганы буюу хонины нэхийний зооны зузаан хэсгийг гурван удаа элдэж, гурав дахин утаж боловсруулсан арьсаар хийсэн шуудаг өмсдөг байжээ. Энэ нь бүр манай тооллоос өмнө Монгол угсааны зарим аймагт бөхийн хувцасыг ямаа, гөрөөсний арьсыг битүүгээр нь туламлан авч элдээд хийж байсны үлдэц уламжлал бололтой.<sup>1</sup>

Толгойгоо 3-4 алд бөсөөр орооно. Энэ нь цэнхэр өнгийн хадаг юм уу, эсвэл торгомсог зүйлс байна. Хойд талдаа (дагзандаа) хоёр үзүүрийг нь нийлүүлж, мушгин (нар зөв) эргүүлнэ. Толгойгоо ороодог энэ бөсийг "хөтөлбөр" гэнэ.

Хөтөлбөрөөс барьж авах хүнийг хөтөлгөө (засуул) гэнэ.



Зураг 1

<sup>1</sup> Л.Ням-Осор, Б.Батсүх. Монгол бөхийн хөгжилт. УБ. 1989.

Дэлж гарахдаа хөл гараа зөрүүлж ороолдож угзарч, татаж байгаа мэт гарна. Ингэж дэлэхийг, "хэвлэх" гэнэ.



Зураг 2

Тугийн өмнө очоод хоёр гараа тулан сөгдөн сууна. Оноо (учраа) нь ирж зэрэгцэн сууна. Дараа нь босч барилдах болохоор толгойн боолтыг нь авна. Энэ үед шороо атгаж авч, гуяа чанга алгадна.



Зураг 3

Шууд хав дөрвөлжин барьдаг



Зураг 4

Давсан бөх нь дэвж ихэс ноёдын өмнө очоод, баруун өвдгөө сөгдөн хүндэтгэлтэйгээр идээ авна. Бөх идээний дээжийг эхлээд хөтөлгөөдөө өгч, дараа нь бусад хүмүүст амсуулаад цацна. Буцахдаа зөв тал буюу зүүн талаар буцна. Үүний дараа давааны шагналыг хүзүүн дээгүүр нь урдаас нь хойш нь тохож өгнө. (Энэ нь олз, хийморийг биенд нь шингээн тогтоож байгаа бэлгэдэл гэнэ).



Зураг 5



Энэхүү давааны шагнал байг "Уяа мөрий" гэнэ. Давааны тоогоор "Уяа мөрий" өгнө. Уяа мөрийг тухайн хошуунаас нь өгнө. Үзүүр түрүүний хоёр бөхийг гарахад тус тусын хошууны ардууд "Цагаан тэмээ" бололцож байгаа мэт зогсоод ханарч унадаг байсан. Түрүүлсэн бөхийн шагнал нь эмээл, хазаартай морь байдаг байжээ. Буцах замд нь энэ мөрийд ах дүү төрөл садан нь очиж хадаг уядаг байжээ.

Бух ноолдооны хөтөлгөө (засуулчид) нар нь урд барилдаж явсан, бух ноолдооны арга мэх, ёс журмыг сайн мэддэг гол төлөв ахмад бөхчүүд байдаг. Бух ноолдоонд бөхийн цол дууддаггүй. Засуулчид тойруул малгай, торгон хантааз өмсдөг байжээ.

Засуулчид барилдааны явцыг хянамгай ажиглан, эгзэгтэй үед нь өөрийн засаж буй бөхөд чухал санаа мэхийг дохио зангаагаар ойлгуулахын хамт бөх нь уяж барилдвал гуя хонгон дээр нь хулсан саваагаар хорстол шавдан, уурыг нь хүргэх, цочроох, зоригжуулах зэргээр дайчин барилдахыг сануулна. Бух барилдааны бөхчүүд нэг учраатай гурав барилдах ёстой. Үүнийг эхэн мөргүүл, дунд мөргүүл, адаг мөргүүл гэж нэрлэнэ. Эсрэг бөхөө хоёр дал сээрээр нь газарт нэг-хоёр, нэг-хоёр гэж аажимхан тоолтол (3 сек орчим) хөдөлгөөнгүй дарна. Ингэж дарж байхад дээрх бөхийн засуулч нь "дараад бай, дараад бай", гэж дор нь байгаа бөхийн засуулч нь "туйл, туйл" гэж анхааруулж шавдуулна.

Дээр үед далаар нь дарахаас гадна эсрэг бөхийнхөө газарт толгойгоор газарт хатган, гар хөлийг нь дээш хумин газарт хүргэхгүй (3 сек орчим) хөдөлгөөнгүй барьж чадвал бас ялсанд тооцдог байсан гэнэ. Барилдааны өмсгөл хувцас, барилдах ёс журам, барилдаантай холбогдсон зан заншлаас нь үзэхэд бух ноолдоон нь анх бүр ураг төрлийн байгуулал, түүний задралын үед үүсч буй монгол туургатны дундат эртнээс хөгжиж хожим хүртэл байгаа чөлөөт бөхийн барилдааны нэг сонирхолтой хэлбэр мөн гэмээр байна.

Сумо бөх монгол бөхөөс гаралтай байж болох тухай Японд зарим таамаглал байдаг. Монгол бөх, сумо бөх хоёр нь олон жилийн өмнөөс спорт болон хөгжиж дээр үед баатар эрчүүдийг шалгаруулах нэгэн хэрэглүүр болж иржээ. Иймээс ч хаад ноёдын өмнө барилдаж, монгол бөхөд түрүүлсэнд нь хөө хуяг, морь мал, японы сумо бөхөд түрүүлсэнд сэлмээр шагнаж байсан нь сүүлийн үед уламжлагдан хадгалагдаж. Сумо бөх бух ноолдоон хоёр нь нүцгэн шахуу барилддаг нь бас нэг онцлог юм. Монгол бөх сумо бөхийн барилдааны өмнөх ёс төр төстэй байдаг.<sup>2</sup>

Судлаач С.Бадрал: "Монгол бөхийн нэгэн төрөл болох бух ноолдооны сумо бөхтэй төстэй зан заншил, хөдөлгөөн өмсгөл хувцас, биеэ авч яваа байдал, ард түмний бөхчүүдээ үнэлж, хандаж хайрладаг зэргээс үзэхэд монгол, японы ард түмний үндэсний бахархал болсон бөхийн барилдаан нь XIII зууны сүүлч үеэс салсан гарвал нэгтэй болох байж болох юм гэсэн сонирхолтой санаа гаргасан байна. Энэ санаанаас улбаалан хэлэхэд бүр Төв Ази, Монголын говиос хүн Америк тив Японы арлууд руу тархан нүүдэллэхэд бух ноолдоон, сумо бөхийн барилдаан цаашид өөр өөрийн өвөрмөц төрх, арга барилыг олон хөгжиж, өмсгөл, дэг жаяг нь өөрчлөгдсөн бололтой.

Монголчууд эцэг мал азарга, буурын ноцолдоон бух, ухна, хуцны мөргөлдөөнийг өдөр тутам үзэж харж явахдаа хүн байгалийн тулааны ухааныг сэтгэлдээ шинжиж, хүчит бөхчүүдээрээ бахархан тэднийг үлгэр, домог болгон ярилцдаг байснаас улбаалан "Бух ноолдоон"-ыг монгол бөхийн анхны үүсвэр "язгуур бөх" байх гэсэн таамаглал дэвшүүлж байна.

<sup>2</sup> С.Бадрал. Сумо бөх монгол бөхтэй гарвал нэгтэй. "Ил товчоо" сонин. 1997. Дугаар 23

**Abstract:**

**Western Mongolian wrestling “bukh noololdoon” and its traditions, regulations, dressings.**

This article consider common features with other wrestling types and styles, the changes and development. “Bukh noololdon” occupies sound position in present.

Ancestors of Mongols have watched ox, camel stallion and other he-animals fights, analyzing and adopting its specifics in martial arts. Shamanistic ritual mutter, songs, melodies and moves are similar to Mongolian wrestling title songs and rituals. Thus considering that “bukh noololdon” is original Mongolian wrestling.